



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар Э/027

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хархорин Буудайн шим” хязгаарлагдмал хариуцлагатай компаний гурилын үйлдвэрийг шүүхийн шийдвэрийн дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих санд шилжүүлэхэд хөндлөнгийн хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - Н.Ганболд -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: -Н.Дулам -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

- Д.Батцэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: - Б.Дэлгэрмаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хадгалалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн

2. Хөндлөнгийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101167